

АРХАНГАЙ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2026 оны 06 дугаар сарын 10

Эрдэнэбулган сум

Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 зорилт, 48 арга хэмжээг тусган боловсруулж Цаг уур, орчны шинжилгээний газрын даргаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Энэхүү төлөвлөгөөний эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын “Аргачлал батлах тухай” 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан загварын дагуу гаргаж Цаг уур, орчны шинжилгээний газарт хүргүүлсэн.

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Манай төв нь 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн “Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” А/162 дугаар тушаалаар нэгжийн зохион байгуулалтгүй болж цаг уурын 4 өртөө, 13 харуул, ус судлалын 10 харуул, байгаль орчны шинжилгээний лаборатори, 1 цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны Цэцэрлэг бороо-1 экспедиц, нийт 63 орон тоотойгоор ус цаг уур, орчны шинжилгээний хөтөлбөрт ажлыг гүйцэтгэлээ.

1.1. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд


Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, Засгийн газар болон удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг заасан хугацаанд зохион байгууллаа.

Байгууллагын дарга, ерөнхий нчгтлан бодогч нар Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ээ АТГ-ын meduuleg.iaac.mn сайтад цахим хэлбэрээр хуулийн хугацаанд мэдүүлж баталгаажуулан, баталгааны маягтыг Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ)-ын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.

Ахмадын зөвлөл, Өмч хамгаалах байнгын зөвлөл, Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, Мэргэшлийн зэргийн салбар ажлын хэсэг зэрэг байнгын ажлын хэсэг, зөвлөлүүд үйл ажиллагаагаа хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна.

Ажлын байранд нийгэм, сэтгэлзүйн эрүүл, эерэг орчныг бүрдүүлэх зорилгоор “Ажлын байранд нийгэм-сэтгэлзүйн эрүүл орчныг бүрдүүлцгээ” аяныг зохион байгуулан хэрэгжүүлэв.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдсан “Эрүүл мэндийн жим – Өглөөний алхалт” арга хэмжээнд албан хаагчдыг долоо хоног бүрийн 1, 3, 5 дахь өдрүүдэд тогтмол хамруулан, идэвхтэй оролцоог хангаж ажиллав. 07 дугаар багийн өрхийн эрүүл мэндийн төвөөс сахар болон өндөр, жингийн үзлэгт хамрагдсан.



Зураг.1.Аймгаас зохион байгуулагдсан үйл ажиллагаанд оролцож буй

Онцгой байдлын газраас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын орчны өнжмөл өвсийг хадаж, хог хаягдлыг бүрэн цэвэрлэн ажиллав.



Зураг.2.Хашааны өнжмөл өвс хадсан

Байгууллагын 90 жилийн ойг угтан зохион байгуулсан “Шатрын нээлттэй тэмцээн”-д том хүн, хүүхдийн ангиллаар нийт 60 гаруй оролцогч хамрагдав. Тэмцээний эрэгтэй, эмэгтэй ангиллын 1–3 дугаар байр, тусгай байр болон насны ангилал тус бүрийн шилдэг оролцогчдыг шагнаж урамшуулав.



Зураг.3.Шатрын тэмцээн зохион байгуулсан байдал

2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хамтран ажилладаг байгууллагуудын дунд байгууллагын 90 жилийн ойг угтсан гар бөмбөг, корн холл, ширээний теннисний төрлүүдээр спортын тэмцээн зохион байгуулж, байгууллага хоорондын хамтын ажиллагаа, нөхөрсөг харилцааг бэхжүүлэв.



Зураг.4.Гурван төрөлд тэмцээн зохион байгуулсан байдал

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан Урдтамир голын эрэг дагуу 40 ширхэг улиас мод тарьж, тарьсан моддын арчилгаа, усалгааг 05 дугаар сарын 22, 29-ний өдрүүдэд тус тус хийж гүйцэтгэв.



Зураг.5.Мод тарьсан байдал

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дэргэдэх Эцэг, эхийн зөвлөлөөс байгууллагын ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийн дунд “Миний мэдэх хүүхдийн баяр” сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгуулж, хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, оролцоог дэмжин оролцогч хүүхдүүдийг шагнаж урамшуулсан.



Зураг.6.Уралдаан зарлаж урамшуулсан байдал

Байгууллагын түүхт 90 жилийн ойд зориулж сар бүр 1-2 ажил зохион байгуулахаар төлөвлөж ажиллаа. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, хамтран ажиллах талаар бүх сумдын Засаг дарга, Тамгын дарга нарт цахим сургалт хийж нийт 50 гаруй хүн оролцов.

Мөн байгууллагын 2027 оны төсвийн төсөлд санал авч тооцоо судалгааг оруулж өгсөн.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан pm.hrs.gov.mn цахимд шивэгдсэн. Бүх сургалтуудад хамрагдсан.

10 сумаас захиалгын дагуу ЦАЗН-өөр үйлчилсэн. 1, 8 дугаар сарын явуул судалгааны шатахууны материалыг бүрдүүлж УЦУСМХ-ээс авсан. ӨХБЗ цаг үеийн асуудлаар хуралдсан ба шалгуулсан 84%-тай дүгнэгдсэн.

Гамшгийн төлөвлөгөө, мэргэжлийн анги, штабын бие бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулсан. 3 дугаар сард ОБГ-аас сургалт авсан, дуут дохиогоор жагссан, аранзны үзлэгт орсон. ОБЕГ-аас аймгийн Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилтад 2026 оны 06 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд мэргэжлийн анги, штабын бие бүрэлдэхүүн хамрагдсан.

ХОЁР. ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЛААР

2.1 Ус, цаг уур, орчны шинжилгээний ажлын талаар

Цаг уурын судалгаа, шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу гүйцэтгүүлж мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгууллаа.

2.1.1 Цаг уурын судалгаа, шинжилгээний ажлын талаар

Цаг уурын шинжилгээний ажлын дүн 2026 оны 06 дугаар сарын 04-ний байдлаар ажиглалтын чанар 98.6%, шүүмжийн чанар 99.6%, дундаж үзүүлэлт 99.1%-тай байна.

2.1.2 Хөдөө аж ахуйн цаг уурын ажлын талаар

Хөдөө аж ахуйн цаг уурын судалгаа шинжилгээний хөтөлбөрийн дагуу гүйцэтгүүлж мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулсан.

2026 оны 1 дүгээр сарын 3 дугаар 10 хоногт Аймгийн 17 сумын 88 багт өвлийн бэлчээрийн судалгааг мониторингийн 88 цэгт хийж, цасны болон өвөлжилтийн байдлыг тодорхойлж иргэдэд үйлчилсэн. Эрдэнэмандал, Их-Тамир сумдын нутгаар нийт нутгийн 60 хүртэлх хувьд цасан бүрхүүл тогтоогүй байсан учир зааврын дагуу явуул судалгааг хийгээгүй.

06 дугаар сарын 04-ний байдлаар Агро дундаж мэдээний ирц 100%, хөтөлбөрийн биелэлт 100%, ажиглалтын мэдээний бүтэц 100% ажиглалтын мэдээний чанар 100%, шүүмж шалгалт-100%,

Шинжилгээний ажлын дундаж дүн: 100%

2.1.3 Усны шинжилгээ судалгааны ажлын талаар

Усны шинжилгээ, судалгаа, мэдээлэл үйлчилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу гүйцэтгэх, ус судлалын 10 харуулыг мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгууллаа.

06 дугаар сарын 05-ны байдлаар Шинжилгээний ажлын дундаж дүн 100 %

2.1.4 Байгаль орчны шинжилгээний ажлын талаар

Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2022 оны 12 сарын 30 өдрийн А/167 тоот тушаалаар MNS/ISO 17025:2018 стандартын шаардлага ханган итгэмжлэгдсэн лаборатори болсон.

2020-2022 онд Байгаль орчны шинжилгээний лаборатори (БОШЛ)-ийг сайжруулах “ТА-9440-MON усны засаглалыг шинэлэг арга замаар хэрэгжүүлэх нь” загвар төсөл хэрэгжиж техникийн шинэчилэл хийгдэж өндөр нарийвчилалтай орчин үеийн багаж төхөөрөмжөөр хангагдсан байна.

2026 оны 6 дугаар сарын 11-нд БНСУ-ын PM10 тоосонцор хэмжигч автомат багаж суурилуулсан.



Зураг.7.БОШЛ-ийн тоног төхөөрөмж

06 дугаар сарын 05-ны байдлаар хөтөлбөрийн биелэлт 100%, агаарын чанарын хоногийн мэдээ, усны чанарын мэдээ бүрэн дамжуулсан ирц 100%.

2025 оны Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тооллогыг журмын дагуу 19 суманд зохион байгуулж, ажлын хэсэг байгуулан ажиллав. Тооллогын дүн мэдээг журмын хавсралт 6, 7 дугаар маягтын дагуу нэгтгэн, 2026 оны 03 дугаар сарын 15-ны дотор аймгийн ЗДТГ болон Цаг уур, орчны шинжилгээний газрын Орчны шинжилгээний хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.

2.1.5 Цаг уурын автомат станц, багаж , хэмжил зүй, баталгаажуулалтын талаар

2004 оноос техник технологийн шинэчлэлт хийгдэж анхны автомат цаг уурын станцыг суурилуулсан.2008, 2015 онд Финлянд, 2018, 2023-2024 онд БНСУ-ын цаг уурын автомат станц суурилуулсанаар цаг уурын 17 салбарт автомат станцаар ажиглалт, хэмжилт хийж мэдээ мэдээллээр үйлчилж байна.

Автомат станцуудын программ хангамжийн хувьд 2026 оны 01 дүгээр сард LoggerNet-программ дээр ажиллаж суран БНСУ-д үйлдвэрлэсэн 11 ширхэг автомат станцад IP хаяг шинэчлэн 202.70.33.36 болгон тохируулж ажилд оруулсан.

AWS-310 цаг уурын автомат станцын IP хаяг шинэчлэхэд D560 GPS DTU программ дээр ажиллан 202.70.33.41 болгон шинэчлэн тохируулж ажилд оруулсан.

AWS-310 автомат станцуудын программ хангамж Weather Platform системд нэвтрэх ашиглах эрхийг шинээр Төвшрүүлэх өртөө, Чулуут, Өгийнуур харуулд авч өгч ашиглаж байна.

2026 оны 04 дүгээр сард эталон хоёр багажийг БОХЗТЛ-д, RDS110 цацрагийн багажийг ЦЕГ-т тус тус баталгаажуулалтад оруулж гэрчилгээг авсан.

2.1.6 Архив, мэдээллийн дэд сангийн талаар

M_WAMS болон Cliware-2.1 цахим удирдлагын систем, программ хангамжийг архив, мэдээллийн дэд сангийн үйл ажиллагаанд ашиглаж байна. Ерөнхий нягтлан бодогчоос цаасан суурьтай 27 хн, Бичиг хэрэг, хүний нөөцөөс 22 хн, Ерөнхий технологич инженер 5хн, Урьдчилан мэдээлэхийн технологич инженер 1 хн, нярав 2 хн нийт 57 хн хүлээн авсан. Цахим баримт нийт 44 хэмжээ 4264,21 mb баримт нягтлан шалгалт хийж хүлээн авсан.

Шинжилгээний архив-99,9% мэдээллийн дэд сангийн -99,9%

2.1.7 Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа

ЦУОШГ-ын даргын 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр А/57 тушаалын дагуу сумдаас ирүүлсэн захиалгаар 04 сарын 07-08-нд Эрдэнэмандал, Цэцэрлэг, 04 сарын 29-нд. Жаргалант, Эрдэнэмандал, 05 сарын 13-нд Цэцэрлэг Хайрхан, Өлзийт, 05 сарын 16-нд Цахир, 05 сарын 21-нд Өгийнуур, 22нд Хашаат сумдын нутгаар тус тус цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулсан.Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны акт болон код мэдээг тухай бүр цаг хугацаанд Цаг уур, орчны шинжилгээний газарт хүргүүлсэн. Цаг уур, орчны шинжилгээний газраас 2026 оны 03 дугаар сард 20 ш пуужинг татан авч пуужингийн нөөцийг нэмэгдүүлсэн. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 5 удаа явуулсан .Үүнд:

- Эрдэнэмандал-2удаа,4ш пуужин
- Цэцэрлэг-2удаа 5ш+2ш пуужин
- Жаргалант-1 удаа ,2ш пуужин
- Өлзийт-1 удаа ,2ш пуужин -Хайрхан1 удаа ,2ш пуужин, -Цахир 1 удаа ,3ш пуужин
- Хашаат 1 удаа , 2ш пуужин
- Өгийнуур 1 дуаа 2ш пуужин

нийт 24ш пуужин зарцуулсан.

2.1.8 Шалган туслах ажлын талаар

Орхон-Өлзийт, Урд, Хойд тамирын голын ус судлалын харуулд очиж шалган туслах хийлээ. Ус, цаг уурын өртөө, харуулд цахимаар 2 удаа шалган туслах ажиллаж заавар зөвлөмж өглөө.

2.2 Мэдээлэл үйлчилгээний ажлын талаар

Цаг агаарын хагас хоног, 1 хоног, 5 хоног, 7 хоногийн урьдчилсан мэдээ, сар, улирлын төлөв мэдээг гаргаж цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл болох нөхцөл бүрдсэн үед 48-72 цагийн өмнө малчид, тээвэрчид иргэд, аж ахуйн нэгжид мэдээлж цаг агаарын бодит мэдээ мэдээллээр шуурхай үйлчилэх ажлыг зохион байгуулсан. Үүнд:

Нарийвчилсан, 1 болон 5 хоногийн урьдчилсан мэдээний таарц, дээрх урьдчилсан мэдээнүүдийн дундаж таарц 97.7%, Ирц 100%.

05 дугаар сарын 31-ний байдлаар 151 удаа үйлчилсэн.Дундаж таарц -97.8%

Архангай аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хуурайшилтын зэргийг 72 удаа бодож, 7 хоног бүрийн Даваа гарагт тархалтын зураглалыг боловсруулж аймгийн Онцгой байдлын газарт нийт 10 удаа мэдээгээр үйлчилсэн.

Цаг агаарын 1 хоногийн тойм мэдээ 151, 7 хоногийн тойм мэдээ 21 удаа тус тус гаргаж холбогдох сайтуудад байршуулж үйлчилсэн. Архангай цаг уур facebook болон Page хуудас, <https://arkhangai.weather.gov.mn/>-д байршуулан үйлчилсэн.. (<https://arkhangai.weather.gov.mn/>-д байршуулсан мэдээ мэдээлэл Arkhangai namem.gov.mn болон gov.mn сайтад) линкээр холбогдон тавигдаж байна.

2.2.1 Цаг агаарын тойм болон урьдчилсан мэдээ

Климат мэдээний ирц, чанар

Цэцэрлэг, Төвшрүүлэх, Эрдэнэмандал, Тариат цаг уурын өртөөний арав хоног, сарын климат мэдээг сар бүрийн 01, 11, 21-нд серверт орсон тухай бүрт хянав. Аюул агаар мэдээ 574, сарын климат мэдээ 6 удаа, 10 хоногийн климат мэдээ 15 удаа

Ирц 100%

Чанар 99.8%

Дундаж 99.9%

Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчилсэн байдал

Нислэгийн цаг уурын төвтэй <http://amc.namem.gov.mn/>, FTP болон mail хаяг, утсаар мэдээ болон заавар зөвлөмжийг солилцож, сар бүр өмнөх сарын мэдээний таарцыг дүгнэсэн байна. 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хүртэл орон нутагт 7 нислэг үйлдэгдсэн.

Мэдээний чанар 100%.

мэдээ зохиолт чанар 91,0%

2.2.3 Холбоо, сүлжээ, цахим хуудасны талаар

Цаг уурын 4 өртөө, Хөдөө аж ахуйн цаг уурын 13 харуул, мэдээнүүдэд сүлжээнээс шалтгаалсан мэдээний хоцрогдол, тасалдал, гэмтэл саатал гараагүй.

Мэдээ дамжуулалтын чанар 99.9%

Мэдээ солилцооны чанар 100%

Сүлжээ ашиглалт, 100%

Тоног төхөөрөмжийн бэлэн байдал, 100%, Дундаж 100%

2026 оны 06 дугаар сарын 04-ний байдлаар Төвшрүүлэх өртөө-1 компьютер, Хяналтын камер-1, Урьдчилан мэдээлэхийн -1, Ус судлалын -1, ЦУ, ХААЦУ техникч, инженер-2, ЦАЗН-1, БОШЛ-1 компьютерүүдэд, болон тоног төхөөрөмжид (нийт 8) засвар үйлчилгээ хийсэн.

2026 оны 01 дүгээр улиралд 28 нэр төрлийн мэдээг 100% байршуулсан. 97% хувьтай үнэлэгдсэн. 2026 оны 06 дугаар сарын 04-ний байдлаар 2 дугаар улирлын тайланг 28 нэр, төрлийн мэдээг байршуулах ажил 85 хувийн явцтай байна. Мэдээлэл үйлчилгээний чиглэлээр 70 гаруй, мэргэжлээ сурталчилсан сургалт, үйл ажиллагааны 7, байгууллагын бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл 30, Нийт 90 гаруй мэдээ байршуулсан.

ГУРАВ.ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ТАЛААР

2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 55 мэдээг 100% хуулийн хугацаанд байршуулж, улирлын тайлан 2 удаа илгээсэн.

2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2026 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр Сангийн яамны Е-Тайлан болон <https://finperform.mof.gov.mn/цахим> системд шивж илгээн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газраар баталгаажуулан “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч, 2026 оны 02 дугаар сарын 12-13-ны өдөр ЦУОШГ-ын нэгдсэн тайланд нэгтгүүлсэн.

2025 оны 4, 2026 оны 1 дүгээр улирлын татварын тайланг хуулийн хугацаанд тайлагнасан.

2025 оны 12, 2026 оны 01-04 дүгээр сарын нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд тайлагнаж баталгаажуулсан.

3.1 Батлагдсан төсөв, хөрөнгө оруулалтын талаар

2026 оны 4 дүгээр сарын байдлаар 758,705.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 736,735.9 мянган төгрөгийг зарцуулсан. Нэмэлт санхүүжилтын дансаар 2025 оны үйл ажиллагааны давсан орлого болох 89.2 мянган төгрөгийг авч зарцуулсан. Холбогдох хуулийн хэрэгжилт 100%.

Эхний хагас жилийн байгууллагын өмч хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг Төвийн даргын 05 дугаар сарын 29-ний өдрийн А/37 дугаар тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулан, 06 дугаар сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 09-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулан ажиллаж байна.

2026 оны 04 дүгээр сарын гүйцэтгэлээр хөдөлмөрийн хортой нөхцлийн нэмэгдэл 2 албан хаагчид 1,104.4 мянган төгрөг, шөнийн цаг, илүү цаг, нийтээр амрах баяр ёслолын цагийн нэмэгдэл хөлс 39 албан хаагчид 34,543.9 мянган төгрөг, орон нутагт ажилласны нэмэгдэл 63 албан хаагчид 102,527.5 мянган төгрөгийг тус тус холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцон олгоод байна. 2026 оны төсөвт албан томилолтын зардал нийт 1,200.0 мянган төгрөг батлагдсан боловч 12 дугаар сарын төсвийн хуваарьт хуваарилагдсан. Сангийн яамнаас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулахгүй байгаа тул албан томилолтын зардал олгоогүй байна.

2026 оны төсөвт өндөр насны тэтгэвэрт гарах 2 албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 67,887.8 мянган төгрөгөөр тооцож хүргүүлсэн боловч 40 хувь буюу 27,155.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

2026 оны эхний хагас жилд ус, цаг уур, орчны шинжилгээний хөтөлбөрт ажлууд бүрэн хийгдлээ. Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

**АРХАНГАЙ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧ
БӨГӨӨД БАГАЖ ХЭМЖИЛ ЗҮЙ ХАРИУЦСАН
ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР Д.ИХ-ОЮУН**